

Эрхэм уншигч Танаа

Түүхийн тэнхим 1947 онд МУИС-д Нийгмийн ухааны салбарыг анх нээхэд гол мөхлөг нь болж байгуулагджээ. Түүхийн салбарыг 15 оюутантай нээж, онол, мэргэжил, ерөнхий эрдмийн 15 төрлийн хичээлийг судлуулан, "Дунд сургуулийн түүхийн багш" мэргэжлийн дипломтойгоор 1949 онд анхны төгсөлт хийсэн байна. Ийнхүү эх орондоо үндэсний түүхч мэргэжилтэн бэлтгэж эхэлснээс хойш 55 жил болж байна.

Энэ ой болон МУИС-ийн 60 жилийн ойд зориулан сургуулийн эрдэм шинжилгээний бичгийн ээлжийн дугаарыг эрхэм уншигч Таны цэгнэн тунгаах оюуны мэлмийд зул болгон өргөн барьж байна.

Энэ хугацаанд түүхч мэргэжлээр нийт 53 удаа төгсөлт хийж, түүхийн суурь болон салбар шинжлэх ухааны онол, мэдлэг, судалгааны арга зүй, мэргэжил, сурган хүмүүжүүлэх дадлага эзэмшсэн, эх орны болон дэлхий дахины түүхийн боловсролтой 1000 шахам мэргэжлийн түүхчдийг бэлтгэн гаргасан юм. Тус салбарыг төгсөгчид нь түүхч, түүхийн багш, эрдэм шинжилгээний ажилтан, төр, төрийн бус байгууллага, бизнесийн салбарын удирдах ажилтан зэрэг улс орны тухайн үеийн хэрэгцээт янз бүрийн албыг хашиж ирэв.

Түүхийн салбарын төгсөгчдөөс эдүгээ Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын газрын дарга, Төрийн сайд, доктор /Ph/, Ө.Энхтүвшин, Монгол Улсын Их Хурлын гишүүн, доктор /Ph/, дэд профессор Д.Алтай, Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Арвин, Н.Ганъямба, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн гишүүн Ж.Болдбаатар нар төрийн дээд албан тушаалд ажиллаж байна. Мөн БНМАУ-ын Ерөнхий сайдын орлогч, ШУА-ийн Ерөнхийлөгч агсан, Монгол улсын хөдөлмөрийн баатар, төрийн шагналт, академич Б.Ширэндэв, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга асан, доктор /Ph/ Ц.Готов нарын нийгэм, төрийн зүтгэлтнүүд тус тэнхимийн багш, эрхлэгчээр ажиллаж байв. Түүнчлэн Монгол улсын Хөдөлмөрийн баатар Ч.Чулуун, Ардын багш Д.Чойжилсүрэн, Гавъяат багш Ч.Базаргочоо, Н.Мижиддорж, С.Норовсамбуу, Х.Зандраабал, Ц.Сүрэнхорлоо, Д.Цэрэннадмид, Шинжлэх ухааны гавъяат ажилтан Л.Жамсран, Ш.Нацагдорж, спортын гавъяат мастер Р.Зориг, Ц.Шоовдор, нар манай салбарыг төгссөн бөлгөө. Манай төгсөгчид болон багшилж байсан хүмүүсээс эрдэмтэн Ш.Нацагдорж, Ж.Пүрэв, Х.Пэрлээ, Б.Ширэндэв нар Монгол Улсын төрийн шагнал хүртсэн юм.

Тус салбарыг төгсөгчдөөс академич 3, шинжлэх ухааны доктор 16, боловсролын доктор 62 төржээ. Тэдний дотроос түүхийн шинжлэх ухааны хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан академич Ш.Нацагдорж, Х.Пэрлээ, С.Норовсамбуу, доктор, профессор Лха.Бат-Очир, Ж.Болдбаатар, Д.Гонгор, С.Дамдинсүрэн, Б.Дашзэвэг, И.Дашням, Л.Жамсран, А.Минис, С.Пүрэвжав, М.Санждорж, Г.Сүхбаатар, профессор Лу.Бат-Очир, Ц.Сүрэнхорлоо нарын нэрийг онцлон дурдаж болох юм.

Түүхийн шинжлэх ухаанаар эрдмийн зэрэг хамгаалсан хүмүүсийн 60 орчим хувь нь МУИС-ийн түүхийн анги төгсөгчид байна.

1980-иад оноос түүхийн салбарт суралцагчид түүхийн суурь, салбар болон хавсрага ухаан, судалгааны арга зүйг нарийвчлан судалж, түүхийн багш, түүхч-архивч, түүхч-музей судлаач зэрэг нарийн мэргэжлээр төгсөх болов.

1990-ээд оноос түүхийн тэнхмээс археологи-антропологиин тэнхим, угсаатан судлалын тэнхим салж, бие даасан салбар болов.

Түүхийн тэнхим бакалаврын сургалт явуулахын зэрэгцээ магистрантур, докторантурын сургалт явуулж байна. Тус тэнхимд түшиглэн түүхийн шинжлэх ухаанаар боловсролын докторын зэрэг хамгаалуулах зөвлөл 1999 онд байгуулагдснаас хойш 10 шахам хүнийг хамгаалуулжээ. Тус тэнхимийн магистрантурыг 100 шахам хүн төгсчээ. Өдгөө 20 шахам хүн магистрантурт, 10 гаруй хүн докторантурт суралцаж байна.

Тус тэнхим сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, хичээлийн тодорхойлолтуудаа шинэчилж, кредит үнэлгээнд шилжин, мэдлэг шалгах тестийн сангаа тогтмол баяжуулж, оюутны бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх арга замыг эрэлхийлэн ажиллаж ирэв. Мөн "Нүүдэлчдийн удам-Хөх Монгол" сэдэвт монголын түүхийн 14 бүлэг сургалтын кино хийж, хичээлд ашиглаж байна.

Түүхийн тэнхимийн эрхлэгчээр академич Б.Ширэндэв, доктор, профессор Л.Жамсран, доктор Б.Түдэв, доктор, профессор С.Пүрэвжав, доктор /Ph/, профессор Э.Чимэдцэрэн, доктор /Ph/, дэд профессор Ц.Санжаасүрэн, доктор /Ph/, профессор Лу.Бат-Очир, доктор /Ph/, профессор Д.Хүүхэнбаатар, доктор, профессор Ж.Болдбаатар нарын нэрд гарсан эрдэмтэд ажиллаж ирэв.

Одоо түүхийн салбар 100 гаруй оюутантай. Тус салбар зөвхөн үндэсний түүхчдийг төдийгүй Оросын Холбооны Улс, Хятад, Унгар, Болгар, Япон, Солонгос, Вьетнам, Лаос зэрэг оронд монгол судлаачдыг бэлтгэн өгч байна.

Эдүгээ түүхийн тэнхим түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Болдбаатар, Д.Өлзийдолгор, доктор /Ph/, профессор З.Баасанжав, Д.Хүүхэнбаатар, Ц.Жамбалсүрэн, З.Лонжид, Л.Чулуунбаатар, Д.Батбаяр, С.Отгонжаргал, доктор /Ph/, дэд профессор У.Гонгоржав, Ж.Урангуа, Д.Сүхбаатар Д.Дашдулам, дэд профессор Б.Ралгаа, докторант Д.Энхцэцэг, Л.Мөнх-Эрдэнэ, П.Дэлгэржаргал, С.Түвшин, Д.Мөнх-Очир, ахлах багш Н.Цогтсайхан, хичээлийн туслах ажилтан М.Баттемер, Л.Ариунаа нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Түүхийн тэнхимийн профессор, багш нар дэлхий дахины түүхийн ханан дээр монголын түүхийн зангилаа асуудлыг судлах, түүхийн шинжлэх ухааны онол-арга зүйг боловсронгуй болгоход чиглэсэн судалгааны ажил хийж ирэв.

Сүүлийн 5 жилд тус тэнхимийн багш нар "Монгол улсын түүх"-ийн V боть, "Монгол улсын түүх" /Түүх, онол-арга зүйн асуудлууд. 30х.х/, "Монголын түүхийн товч тайлбар толь" I, II, III. /40 гаруй х.х/, "Монголын түүхийн хураангуй хэрэглүүн" I-VIII дэвтэр. 35х.х/, "Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэн товчоон" /12х.х/, "Европын түүх" /26 х.х/, "Дэлхийн түүх" /25х.х/ томоохон хамтын бүтээл туурвиж, Ж.Болдбаатар "Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал" /Д.Лүндээжанцантай хамт. 25 х.х/, "Булган хангайн хүчитнүүд" /25х.х/, "Да лам" /6х.х/, "Чингис хаан" /5х.х/, "Дулаан ханы хүү" /5х.х/, "Чин бишрэнлт гүн Хайсан" /4х.х/, Д.Өлзийдолгор "Монгол улсын төрийн тамга" /16 х.х/, "Махасамади Далай цэцэн хан Ц.Навааннэрэн" /Х.Ариун-Эрдэнэтэй хамт. 6х.х/, З.Лонжид "Магсар хурц" /3х.х/, "Санхүүгийн албаны түүх" /7х.х/, "Шудрага баатар Бавуужав" /3х.х/, З.Баасанжав "Түүх заах арга зүйн зарим асуудал" /8х.х/, Ц.Жамбалсүрэн "Монголын түүх /1990-ээд он" /10 х.х/ "Ю.Цэдэнбалаас П.Очирбат хүртэл"

/8,5 х.х/, "XX зууны монгол ажилчин" /11 х.х/, Л.Чулуунбаатар "Шинэ түүхийн хураангуй хэрэглүүн" /4х.х/, "Дэлхийн түүхийн ойрхи үеийн сургамж, шинэчлэлт" /5х.х/, С.Отгонжаргал "XX зууны Монгол дахь улс төрийн үйл явц" /Лу.Бат-очирын хамт. 9х.х/, Ж.Урангуа "XX зууны эхэн үеийн Ар Монгол дахь шинэтгэл" /7х.х/, "Хэргэм, зэрэг, цол өргөмжлөхүй" /7х.х/, Д.Энхцэцэг "Монгол хатад" /Ж.Урангуатай хамт. 14,7 х.х/, Л.Мөнх-Эрдэнэ "Түүхийн гүн ухааны лекцүүд" /9х.х/, "Европын Хүннү ба Атилла" /3х.х/, "Атилла" /4х.х/, Д.Дашдулам "Золбингийн Шижээ" /3х.х/, Д.Сүхбаатар "Монгол улсын нутаг дэвсгэрийн хуваарилалтын түүхэн уламжлал" /11х.х/, На.Сүхбаатар "Баруун хязгаарын нийгэм, улс төрийн хөгжлийн түүхэн тойм" /XX зууны эхэн үеэс 30-аад он. 7х.х/, "Ойрад Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд /I,II дэвтэр.30х.х/ зэрэг бүтээлүүдийг туурвижээ.

З.Баасанжав, З.Лонжид, Д.Энхцэцэг нар ерөнхий боловсролын дунд сургуульд зориулсан "Хүн төрөлхтний соёл иргэншлийн түүх", "Монгол улсын түүх"-ийн сурах бичгүүдийг зохиоход оролцжээ.

Одоо тус тэнхим "Соросын сан"-гийн ивээлээр "Дэлхийн түүх" I,II ботийг туурвин дуусгаж байна.

Сүүлийн 5 жилд "XX зууны Монголын түүхийн зангилаа асуудал" /1998 он/, "Түүхийн судалгааны онол-арга зүйн асуудал" /1999 он/, "Манжийн эрхшээлийн үеийн Монгол орон" /2000 он/, "Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, шинэчлэл" /2001 он/, "Монгол-Солонгосын түүхчдийн симпозиум" /2001 он/, "1911 оны үндэсний хувьсгал" /2001 он/ сэдвээр улсын хэмжээний эрдэм шинжилгээний бага хурал, "Үлэмжийн их Чингис хаан" /2002 он/ олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг бие даан болон ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Үндэсний Архивын Газар, Судалгааны "Прогноз" төв, Ханнс Зайделийн сан зэрэг газруудтай хамтран зохион байгуулжээ.

55 жилийн тэртээгээс үндэсний түүхчдийг системтэй бэлтгэж эхэлсэн МУИС-ийн түүхийн салбар нь манай улсын түүхийн сургалт, судалгаа явуулах, түүхч, түүхийн багш нарыг бэлтгэх гол уурхай болж ирсэн бөгөөд ардчилал, зах зээлийн нөхцөлд үйл ажиллагаа нь улам өргөжин тэлсээр байна.

"Түүх" сэтгүүл нь зөвхөн түүхчид төдийгүй түүх, түүхийн философи, онол-арга зүйн асуудлаар судалгаа, шинжилгээ явуулдаг нийгмийн ухааны эрдэмтэд, судлаачид, Монгол улсын түүх сонирхогчидтой санал бодол өргөн солилцож, өгүүлэл, архивын материал, түүхэн гэрчийн дуртгал, дурсамж, түүхэн фото зургийг хэвлэн нийтлэх болно.

Номын буян дэлгэрэн орших болтугай.

Сэтгүүлийн зөвлөл